БАТЛАВ:
……
……..

БАТЛАВ:
“КОМТЕЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....Б.НОМИНТАНА

**ИНТЕРНЭТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ**

2026 оны …-р сарын … өдөр №..... Улаанбаатар хот

Нэг талаас “КОМТЕЛ” ХХК /хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар 9011105069, регистрийн дугаар 2669188/ (цаашид “Нийлүүлэгч” гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Номинтана, нөгөө талаас ..... (цаашид “Хэрэглэгч”, хамтад нь “Талууд” гэх) нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

## 1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь Хэрэглэгчид интернэтийн үйлчилгээ үзүүлэх, Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөрийг төлөхтэй холбогдон Талуудын хооронд үүсэх эрх, үүрэг, харилцааг зохицуулна.

## 2. ИНТЕРНЭТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ, ХУГАЦАА

2.1. Нийлүүлэгч нь Хэрэглэгчид шилэн кабелиар **dedicated** төрлийн интернэт үйлчилгээ үзүүлнэ.

2.2. Хэрэглэгчийн Улаанбаатар хот, ..... хаягт орших ажлын байранд …… Ай пи хаягт ..... **mbps** хурдтай интернэт үйлчилгээ үзүүлнэ. Үйлчилгээний үнэ, төлбөрийн мэдээллийг энэхүү гэрээний Хавсралт №1-д тусгав.

2.3. Хэрэглэгчийн холболтын техникийн нөхцөлөөс хамааран Монгол Улс доторх харилцан холболтын сүлжээ /MIX/ болон Нийлүүлэгчийн дотоод сүлжээнд холбогдох хурд харилцан адилгүй байна.

2.4. Шилэн кабелийн болон UTP кабелийн холболттой Хэрэглэгч нь Монгол Улс доторх MIX болон Нийлүүлэгчийн дотоод сүлжээнд тухайн холболтын интерфейсийн техникийн боломжит хурдаар холбогдоно.

2.5. Нийлүүлэгчийн хүргэж байгаа 2.2-т заасан интернэтийн үйлчилгээний хурдыг Харилцаа холбооны зохицуулах хороо /ХХЗХ/-оос эрхлэн гаргасан www.speedtest.mn цахим хуудсанд хандан шалгах боломжтой ба үйлчилгээний талаар санал хүсэлтээ info@comtel.mn мэйл хаягаар болон 88882043 утсаар илэрхийлэх боломжтой.

2.6. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг гэрээний Хавсралт №1-д заасны дагуу 2.2-т заасан хаягт суурилуулна.

2.7. Хэрэглэгч нь төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулахад шаардагдах нөхцөл (байр, цахилгаан гм)-ийг бүрдүүлнэ.

2.8. Энэхүү гэрээ нь Талууд гарын үсэг зурж, тэмдэг дарсан өдрөөс хүчин төгөлдөр болох бөгөөд интернэт үйлчилгээний үндсэн хугацаа нь үйлчилгээг суурилуулж, Хэрэглэгчид хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай байна. Аль нэг Тал гэрээг сунгахгүй бол гэрээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ. Дээрх хугацаанд мэдэгдээгүй бол гэрээ 1 жилийн хугацаагаар автоматаар сунгагдана.

## 3. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР ТООЦОО

3.1. Интернэтийн үйлчилгээний сарын төлбөрийг холболт хийгдэж, Хэрэглэгчид хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн тооцно.

3.2. Нийлүүлэгч сар бүрийн 5-ны дотор тухайн сарын интернэтийн үйлчилгээний төлбөрийг нэхэмжлэх ба хэрэглэгч тухайн сарын 20-ны дотор нэхэмжилсэн төлбөрийг Хаан банкны **5063105721 тоот** дансанд төлнө.

3.3. Хэрэглэгч тал дансаар үйлчилгээний төлбөр тушаахдаа гүйлгээний утга хэсэг дээр гэрээ байгуулсан байгууллага болон хувь хүний нэрийг заавал бичнэ.

3.4. Хэрэглэгч нь энэхүү гэрээний 3.2-д заагдсан хугацаанд төлбөрөө төлөх үүрэгтэй.

3.5. Хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч төлбөрийн хугацаа хэтэрсэн тухай сануулга хүргүүлнэ. Сануулга хүргүүлснээс хойш төлбөрийг бүрэн барагдуулаагүй тохиолдолд Нийлүүлэгч үйлчилгээг түр хаах эрхтэй.

3.6. Нийлүүлэгчийн хариуцах сүлжээ, тоног төхөөрөмжөөс шалтгаалсан тасалдлын хугацааг Нийлүүлэгчийн мониторингийн систем, гэмтлийн дуудлагын бүртгэл болон шаардлагатай тохиолдолд Талуудын үйлдсэн актаар тогтооно. Баталгаажсан тасалдлын хугацаанд ногдох үйлчилгээний төлбөрийг Талууд харилцан тохиролцож, дараагийн сарын төлбөрөөс хувь тэнцүүлэн хасаж болно.

3.7. Хэрэглэгчийн буруугаас болж Интернэтийн холболт тасарсан тохиолдолд тухайн сарын төлбөрт өөрчлөлт орохгүй болно.

3.8. Хэрэглэгчийн хүсэлтээр үйлчилгээг түр хаасан тохиолдолд хаасан өдрөөс үйлчилгээг сэргээх хүртэлх хугацаанд үйлчилгээний төлбөр тооцохгүй. Төлбөрийн үлдэгдлийн улмаас үйлчилгээ хаагдсан тохиолдолд үйлчилгээ хаагдсан өдрөөс хойших хугацаанд сарын төлбөр тооцохгүй бөгөөд өмнө үүссэн төлбөрийн өр хэвээр үлдэнэ.

3.9. Хэрэглэгч сарын дундуур холболтоо сэргээлгэсэн болон шинээр холбогдсон тохиолдолд Нийлүүлэгч нь сарын төлбөрийг холболт хийгдсэн өдрөөс эхлэн тооцож дараа сарын төлбөр дээр нэмж авна.

3.10. Хэрэглэгчийн хүсэлтээр сарын дундуур үйлчилгээг цуцалсан тохиолдолд Нийлүүлэгч нь тухайн сарын ашиглаагүй хоногийн төлбөрийг урьдчилж нэхэмжилсэн сарын төлбөрөөс буцаан олгоно.

3.11. Хэрэглэгчийн хүсэлтээр гэрээ цуцалсан тохиолдолд гэрээнд заасан Нөхөн төлбөрийг сүүлийн төлбөрийн нэхэмжлэлд нэмж нэхэмжилнэ. Хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг 3 ба түүнээс дээш сарын хугацаанд төлөөгүй үндэслэлээр гэрээ цуцлагдсан тохиолдолд тухайн үеийн төлбөрийн үлдэгдэл болон гэрээнд заасан Нөхөн төлбөрийг хамтад нь нэхэмжилнэ.

3.12. Нийлүүлэгчийн хариуцах холболтын хүрээнээс гадуурх Хэрэглэгчийн дотоод сүлжээ, компьютер, сервер болон бусад тоног төхөөрөмжид Хэрэглэгчийн хүсэлтээр оношилгоо, тохиргоо, засвар үйлчилгээ хийсэн тохиолдолд тухайн ажил үйлчилгээнд зарцуулсан ажлын хөлс, материал болон шаардлагатай тоног төхөөрөмжийн үнийг Хэрэглэгч төлнө. Нийлүүлэгч нь ажил эхлэхээс өмнө үйлчилгээний үнэ, зардлын тооцоог Хэрэглэгчид танилцуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр ажлыг гүйцэтгэнэ.

## 4. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Хэрэглэгч гэрээний үндсэн хугацаа дуусахаас өмнө гэрээг цуцалсан тохиолдолд Хавсралт №1-д тусгасан бодитоор олгосон, төлөгдөөгүй хөнгөлөлтийн үлдэгдлийг нөхөн төлнө. Үүнд тоног төхөөрөмж, холболт, суурилуулалтын хөнгөлөлт багтана.

4.2. Хэрэглэгч интернэт үйлчилгээний тасралтгүй ажиллагааг хянах зорилгоор өөрийн хариуцсан ажилтны мэдээлэл, холбоо барих утас, и-мэйл хаягийг үнэн зөв, бүрэн бөглөж Нийлүүлэгчид хүргүүлнэ.

4.3. Хэрэглэгч өөрийн үндсэн мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 хоногийн дотор Нийлүүлэгчид мэдэгдэх үүрэгтэй.

4.4. Хэрэглэгч төхөөрөмжийг суурилуулах, ажиллуулахад шаардлагатай нөхцөл /байр, цахилгаан хангамж, газардуулга, сувагчлал/-ийг бүрдүүлнэ. Тухайн байранд сүлжээ оруулахад байр, барилгын эзэмшигч болон холбогдох этгээдээс зөвшөөрөл авах шаардлагатай тохиолдолд уг зөвшөөрлийг авахад Нийлүүлэгчид шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллана.

4.5. Хэрэглэгч өөрийн дотоод сүлжээ, компьютер, сервер болон бусад тоног төхөөрөмжийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдал, гадны халдлагаас хамгаалах асуудлыг өөрөө хариуцна.

4.6. Хэрэглэгч үйлчилгээг бодитоор ашигласан эсэхээс үл хамааран гэрээнд заасан үндэслэлээр үйлчилгээ хаагдах, зогсох эсхүл гэрээ цуцлагдах хүртэлх хугацааны үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд үлдэгдэлгүй бүрэн төлөх үүрэгтэй.

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

4.7. Хэрэглэгч тоног төхөөрөмжийг Нийлүүлэгчээс худалдаж аваагүй эсхүл түрээслээгүй тохиолдолд өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, түүнтэй холбоотой зардлыг өөрөө хариуцна.

4.8. Хэрэглэгч үйлчилгээг түр хаалгах, нээлгэх, хурд өөрчлөх, холболтын байршлыг шилжүүлэх буюу нүүлгэх хүсэлтээ Нийлүүлэгчид албан бичгээр эсхүл Талуудын тохиролцсон албан ёсны цахим сувгаар хүргүүлнэ. Хэрэглэгч үйлчилгээг цуцлах эсхүл холболтыг нүүлгэн шилжүүлэх тохиолдолд Нийлүүлэгчид 1 сарын өмнө урьдчилан мэдэгдэнэ.

4.9. Хэрэглэгч үйлчилгээний чанартай холбоотой санал, хүсэлт, гомдол, мөн интернэт холболтын ашиглалттай холбоотой гэмтэл, саатал гарсан тохиолдолд тухай бүр Нийлүүлэгчийн ээлжийн инженер болон гэрээний холбоо барих хэсэгт заасан сувгаар мэдэгдэнэ. Шаардлагатай тохиолдолд Талууд хамтарсан шалгалт хийж гэмтэл, саатлын шалтгааныг тогтооно. Гэмтэл, саатлын эхэлсэн болон бүрэн сэргэсэн хугацааг Нийлүүлэгчийн мониторингийн систем, дуудлагын бүртгэл болон шаардлагатай тохиолдолд Талуудын хамтран үйлдсэн актаар баталгаажуулна.

4.10. Хэрэглэгч интернэтийн холболт, суурилуулалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлсэн тохиолдолд үйлчилгээг хамгийн багадаа 3 сарын хугацаанд ашигласны дараа түр хаалгах эрхтэй болно.

4.11. Хэрэглэгчийн хүсэлтээр интернэт үйлчилгээг түр хаах нийт хугацаа 3 сараас хэтрэхгүй байна.

4.12. Үйлчилгээг түр хаасан 3 сарын хугацаа дуусмагц 4 дэх сараас үйлчилгээ автоматаар нээгдэж, үйлчилгээний төлбөрийг гэрээний дагуу тооцож эхэлнэ. Хэрэглэгч үйлчилгээг цаашид ашиглахгүй тохиолдолд гэрээнд заасан нөхөн төлбөр болон бусад төлбөр тооцоог барагдуулсны үндсэн дээр гэрээг цуцална.

4.13. Нийлүүлэгч шаардлагатай тохиолдолд Хэрэглэгчийн байранд очиж интернэт холболт, тоног төхөөрөмжид шалгалт хийх бөгөөд Хэрэглэгч уг шалгалтыг хийх шаардлагатай нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

4.14. Хэрэглэгчийн байранд суурилуулсан Нийлүүлэгчийн өмчийн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэвийн ашиглалтыг Хэрэглэгч хариуцна. Тоног төхөөрөмж алдагдсан, үрэгдсэн эсхүл Хэрэглэгчийн буруугаас ашиглах боломжгүй болсон тохиолдолд Хэрэглэгч тухайн тоног төхөөрөмжийн үнийг Нийлүүлэгчид нөхөн төлнө.

4.15. Хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг 3 ба түүнээс дээш сарын хугацаанд төлөөгүй тохиолдолд өр, авлагыг барагдуулах зорилгоор Нийлүүлэгч нь хууль тогтоомжид нийцүүлэн шаардлагатай мэдээллийг өр барагдуулах үйл ажиллагаа эрхэлж буй эрх бүхий гуравдагч этгээдэд шилжүүлж болно.

4.16. Нийлүүлэгчийн бичгээр зөвшөөрсний үндсэн дээр хэрэглэгч гэрээг бусдад шилжүүлэх тохиолдолд гэрээнд заасан төлбөр тооцооны дагуу Нийлүүлэгчид төлөх гэрээний дагуу үүссэн бүх төлбөр, өр төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

4.17. Хэрэглэгч шилэн кабелийн холболт, суурилуулалтын хөнгөлөлт эдэлсэн тохиолдолд үйлчилгээг хамгийн багадаа 1 жилийн хугацаанд ашиглана. Хэрэглэгч энэхүү хугацаанд үйлчилгээг цуцлах эсхүл холболтыг нүүлгэн шилжүүлэх тохиолдолд гэрээний хавсралтад заасан шилэн кабель, холболттой холбоотой нөхөн төлбөрийг төлнө.

4.18. Хэрэглэгчийн эзэмшлийн болон ашиглаж буй байр, талбайд гэмтэл, саатлыг тодорхойлох, засвар үйлчилгээ хийх үед ажил гүйцэтгэх аюулгүй орчныг бүрдүүлж, шаардлагатай нэвтрэх болон ажиллах зөвшөөрлөөр хангана.

4.19. Хэрэглэгч үйлчилгээний чанарыг шалгах, өөрийн тоног төхөөрөмж дээр ажиллахдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох стандарт, дүрэм, журмыг мөрдөж, аюулгүй ажиллагааг хангана.

## 5. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Нийлүүлэгч нь хэрэглэгч талаас интернэтийн төлбөрөө хугацаандаа төлөхийг шаардах эрхтэй.

5.2. Нийлүүлэгч нь гэрээ байгуулагдсанаас хойш холболт, суурилуулалтын техникийн нөхцөл бүрдсэн үед Хэрэглэгчийг бүртгэж, эрх үүсгэн интернэт үйлчилгээг холбоно.

5.3. Нийлүүлэгч нь хэрэглэгчид төхөөрөмжийг суурилуулж, техникийн бүрэн бүтэн байдлыг ханган, төхөөрөмж болон холболтыг хүлээлцсэн акт үйлдэж хүлээлгэн өгнө.

5.4. Нийлүүлэгч нь Хэрэглэгчийн үйлчилгээг түр хаалгах, нээлгэх, хурд өөрчлөх хүсэлт бүхий албан бичгийг хүлээн авснаас хойш ажлын 2 хоногт багтаан уг ажлыг шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, төлбөр тооцоог үйлчилгээний нөхцөл өөрчлөгдсөн өдрөөс эхлэн тооцно.

5.5. Нийлүүлэгч нь Хэрэглэгчийн шинэ салбарыг холбох, интернэт холболтыг шилжүүлэх буюу нүүлгэх хүсэлт бүхий албан бичиг авснаас хойш УБ хот дахь шилэн кабелын холболтыг ажлын 21-45 хоногт ажлыг гүйцэтгэнэ.

5.6. Нийлүүлэгч нь Хэрэглэгчийн Улаанбаатар хот дахь интернэтийн холболтыг шилжүүлэх буюу нүүлгэн шилжүүлэх тохиолдолд Хавсралт №1-д заасан суурилуулалтын төлбөрийн хэмжээгээр дахин суурилуулалтын төлбөр нэхэмжилнэ.

5.7. Нийлүүлэгч нь Интернэтийн үйлчилгээний тасралтгүй ажиллагааг хянах зорилгоор ээлжийн болон хариуцлагатай инженерийг 24 цагаар ажиллуулна.

5.8. Нийлүүлэгч нь худалдаалж буй тоног төхөөрөмждөө 6 сарын баталгаат хугацаа, анхны суурилуулалт болон төлбөртэй гүйцэтгэсэн дахин суурилуулалтандаа 1 жилийн баталгаат хугацааг өгнө.

5.9. Баталгаат хугацааг Талуудын хооронд хийгдсэн “Тоног төхөөрөмж, холболт хүлээлцэх акт”-нд гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулсан өдрөөс эхлэн тооцно.

5.10. Нийлүүлэгч нь баталгаат хугацаанд болон түүнээс цааш Хэрэглэгчийн компьютерын дотоод сүлжээ, түүний нууцлал, тасралтгүй ажиллагаа алдагдсан болон төхөөрөмжийн механик гэмтэл, гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас учирсан, эрчим хүчний хэлбэлзлээс шалтгаалсан, байгалийн нөлөө болон ус, шингэн зүйл, гадны биет орсноос үүдсэн, төрөл бүрийн вирусээр дамжсан эвдрэл гэмтэл болон бусад Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбоогүй эвдрэл гэмтлийг хариуцахгүй.

5.11. Нийлүүлэгч нь Хэрэглэгчийн гуравдагч этгээдээс худалдан авсан болон түрээсэлж буй тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцахгүй.

5.12. Нийлүүлэгч нь үйлчилгээний гэмтэл, саатлын шалгалт, оношилгоог шуурхай эхлүүлж, өөрийн хариуцах хүрээнд үүссэн гэмтэл, саатлыг арилгах арга хэмжээ авна. Гуравдагч этгээдийн шугам сүлжээ, нийтийн дэд бүтэц, газар шорооны ажил болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан тохиолдолд сэргээх хугацаа тухайн нөхцөлөөс хамаарна.

5.13. Нийлүүлэгч нь техникийн шинэчлэл, шугам сүлжээний өргөтгөл хийхдээ хэрэглэгчийн үйлчилгээг хязгаарлахгүй байх бүх арга хэмжээг авах ба зайлшгүй тохиолдолд үйлчилгээг хязгаарлах цаг хугацааны талаар хэрэглэгчид урьдчилан мэдэгдэнэ.

5.14. Нийлүүлэгч нь хэрэглэгчийн байранд суурилуулсан кабелийн төгсгөлийн төхөөрөмж хүртэлх ашиглалтыг хариуцаж ажиллана. Хэрэглэгчийн дотоод сүлжээний төхөөрөмж, гуравдагч этгээдээс худалдан авсан болон түрээсэлж буй тоног төхөөрөмжийн ашиглалтыг хэрэглэгч өөрөө хариуцах ба хэрэглэгчийн өгсөн дуудлагын дагуу компанийн ажилтан засвар үйлчилгээ хийвэл гэрээний 3.12-д заасны дагуу төлбөртэй үйлчилгээ үзүүлнэ.

5.15. Нийлүүлэгчийн талаас шалтгаалаагүй хэрэглэгчийн буруутай үйл ажиллагаа, гадны нөлөөнөөс болж төхөөрөмжид гэмтэл гарсан эсхүл хэрэглэгчийн дотоод сүлжээ, компьютер бусад төхөөрөмжийн техникийн гэмтэл, гэнэтийн саатлаас үүдэн үйлчилгээнд доголдол гарсан тохиолдолд Нийлүүлэгч хариуцлага хүлээхгүй. Энэ тохиолдолд нийлүүлэгч нь Хэрэглэгчийн хүсэлтээр сэлбэг материал ба засварын ажлын хөлсийг Хэрэглэгчээс тухайн сардаа нэхэмжилж авах байдлаар засварын ажил хийж өгч болно.

5.16. Нийлүүлэгч нь дараах үндэслэлийн аль нэг нь үүссэн тохиолдолд Хэрэглэгчид бичгээр мэдэгдэж, гэрээг нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй. Үүнд:

5.16.1. Хэрэглэгч үйлчилгээний төлбөрийг 3 сар дараалан хугацаанд нь төлөөгүй бол;

5.16.2. Хэрэглэгч дампуурсан, татан буугдсан, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон нь эрх бүхий байгууллагын шийдвэр, албан ёсны бүртгэлээр тогтоогдсон бол.

5.17. Нийлүүлэгч нь зах зээлийн нөхцөл байдал, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэр болон бусад үндэслэлтэй нөхцөлөөс шалтгаалан үйлчилгээний үнэ тариф, нөхцөлд өөрчлөлт оруулах эрхтэй. Ийм өөрчлөлт оруулах тохиолдолд Хэрэглэгчид ажлын 20-аас доошгүй өдрийн өмнө албан бичиг, цахим шуудан, утас болон Талуудын тохиролцсон бусад боломжит сувгаар мэдэгдэнэ.

5.18. Нийлүүлэгч өөрийн хөрөнгөөр суурилуулсан шилэн кабель, түүний холбогдох дэд бүтэц нь Нийлүүлэгчийн өмч байна. Хэрэглэгч нь Нийлүүлэгчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр уг шилэн кабельд өөрчлөлт оруулах, залгаа хийх, шилжүүлэх, гуравдагч этгээдэд ашиглуулахыг хориглоно.

## 6. НУУЦ ХАДГАЛАХ

6.1. Энэхүү гэрээ, түүний хавсралт, нэмэлт өөрчлөлт болон гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичиг, мэдээлэл нь Талуудын нууцад хамаарна. Энэхүү гэрээнд болон хуульд зааснаас бусад тохиолдолд аль нэг Тал нөгөө Талын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр эдгээрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн гуравдагч этгээдэд дамжуулах, хуулбарлан тараах, нийтэд түгээхийг хориглоно.

6.2. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн нөгөө Талын үйл ажиллагаа, техник технологи, сүлжээний бүтэц, үнэ тариф, хэрэглэгчийн мэдээлэл болон байгууллагын болон хуульд хамгаалагдсан бусад нууц мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахгүй.

6.3. Энэхүү гэрээний энэ бүлэгт заасан нөхцөлийг аль нэг тал зөрчсөн тохиолдолд үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа хохирлыг бүрэн барагдуулна.

## 7. ГЭРЭЭГ ӨӨРЧЛӨХ БУЮУ ЦУЦЛАХ, СУНГАХ

7.1. Дараах үндэслэлийн аль нэг нь байвал гэрээг цуцална:

7.1.1. Аль нэг талаас цуцлах саналыг бичгээр гаргасан бөгөөд талууд харилцан тохиролцсон бол

7.1.2. Аль нэг тал гэрээний үүргээ ноцтойгоор зөрчсөн бол

7.1.3. Хуульд заасан бусад үндэслэлээр.

7.2. Гэрээ дуусгавар болсон нь гэрээ хүчинтэй байх хугацаанд үүссэн төлбөрийн өр, тоног төхөөрөмж буцаан өгөх болон бусад биелэгдээгүй үүргийг хүчингүй болгохгүй.

7.3. Гэрээ дуусгавар болсон тохиолдолд тоног төхөөрөмжийн өмчлөл, буцаан хүлээлгэн өгөх, өмчлөх эрх шилжүүлэх болон үлдэгдэл төлбөрийг энэхүү гэрээ болон Хавсралт №1-д заасан нөхцөлийн дагуу шийдвэрлэнэ.

7.4. Энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг аль нэг Тал нөгөө Талдаа бичгээр гаргаж, Талууд харилцан тохиролцсон тохиолдолд нэмэлт гэрээ байгуулж баталгаажуулна. Гэрээг аль нэг Тал өөрийн санаачилгаар цуцлах тохиолдолд энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол 30-аас доошгүй хоногийн өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ.

7.5. Хэрэглэгч гэрээний 2.8-д заасан үндсэн хугацаа дуусахаас өмнө өөрийн санаачилгаар гэрээг цуцалсан тохиолдолд гэрээ болон Хавсралт №1-д заасан нөхөн төлбөр, үлдэгдэл төлбөрийг Нийлүүлэгчид бүрэн төлнө.

## 8. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл /гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр/-ийн улмаас гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд үүргээ биелүүлээгүй тал хариуцлагаас чөлөөлөгдөнө.

8.2. Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## 9. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

9.1. Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

9.2. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөлөөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжид заасан харьяаллын дагуу эрх бүхий шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 10. АВЛИГЫН ЭСРЭГ ЗААЛТ

10.1. Талууд авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллана.

10.2. Хэрэв талуудын аль нэг нь авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй хэлцэл хийхийг шаардах, хүсэлт тавьбал нөгөө тал нь байгууллагынхаа холбогдох албан тушаалтан танилцуулж, Авлигатай тэмцэх газарт мэдэгдэх үүрэгтэй.

10.3. Энэ үүрэг (10.2-т заасан)-ийг гүйцэтгээгүй болох нь тогтоогдвол тухайн албан тушаалтыг Авлигатай тэмцэх газарт мэдээлэл хүргүүлж шалгуулна.

10.4. Талууд эсрэг талдаа авлига, ашиг сонирхлын шинжтэй санал, хүсэлт тавих, үйлдэл, эс үйлдэл гаргахыг хориглоно.

## 11. БУСАД ЗҮЙЛ

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

11.1. Хэрэглэгч нь Нийлүүлэгчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

11.2. Талуудын удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр байна.

11.3. Энэ гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсад дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.

11.4. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, Тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хувь үйлдэж болно.

11.5. Энэхүү гэрээний хавсралт, нэмэлт болон Талуудын харилцан байгуулсан нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил хүчинтэй байна.

11.6. Энэхүү гэрээнд хугацааг “ажлын өдөр” гэж тусгайлан зааснаас бусад тохиолдолд жил, сар, хоногоор илэрхийлсэн хугацааг хуанлийн тооллоор тооцно.

**Гэрээг баталгаажуулсан**

**Нийлүүлэгчийг төлөөлж**

Нэр: _____

Албан тушаал: _____

Гарын үсэг: _____

**Хэрэглэгчийг төлөөлж**

Нэр: _____

Албан тушаал: _____

Гарын үсэг: _____

Дугаар: _____

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

2026 оны ..-р сарын …-ний өдрийн
.....…….. гэрээний Хавсралт №1

## ХОЛБОО БАРИХ

| Нийлүүлэгчийн мэдээлэл | |
|---|---|
| Нийлүүлэгчийн албан ёсны хаяг: | Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 1-р хороо, 2-р хороолол, 48-р байр, 1 тоот |
| Техникийн тусламж үйлчилгээний утас, и-мэйл: | Утас:<br>И-мэйл: info@comtel.mn |
| **Хэрэглэгчийн мэдээлэл** | |
| Хэрэглэгчийн албан ёсны хаяг: | |
| Төлбөр тооцоо хариуцсан ажилтны нэр, утас, и-мэйл, албан тушаал: | |
| Төлбөрийн нэхэмжлэх хүлээн авах и-мэйл: | |

## ТӨЛБӨРИЙН МЭДЭЭЛЭЛ (НӨАТ тооцсон)

| ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ | |
|---|---|
| Холболтын төрөл | |
| Үйлчилгээний хурд (Мбит/сек) | |
| Үйлчилгээний сарын төлбөр ₮ | |
| Үнэгүй дагалдах IP хаяг | |
| Нэмэлт IP хаягийн тоо | - |
| Нэмэлт IP хаягийн үнэ ₮ /сар бүр/ | - |

| НЭГ УДААГИЙН ТӨЛБӨР ТООЦОО ₮ | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **СУУРИЛУУЛАЛТ** | | | | | |
| Суурилуулалтын үндсэн төлбөр ₮ | | 450,000₮ | | | |
| Суурилуулалтын үндсэн төлбөрийн хөнгөлөлт % | | | | | |
| Суурилуулалтын хөнгөлөгдсөн төлөх төлбөр ₮ | | | | | |
| **ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ** | | | | | |
| Холболтын төрөл | Төхөөрөмжийн нэрс | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ | Өмчлөгч |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| Ажлын хөлс | Тоног төхөөрөмж суурилуулах шилэн кабель татах | | | | |
| Дүн | Дүн | | | | |

| Шилэн кабелийн холболт, хөнгөлөлт | |
|---|---|
| Шилэн кабелийн урт /метр/ | |
| Шилэн кабель, холболтын үндсэн зардал /₮/ | |
| Олгосон хөнгөлөлт /₮/ | |
| Хэрэглэгчийн төлөх төлбөр /₮/ | |
| **Нөхөн төлбөр** | |
| Холболт, суурилуулалтын хөнгөлөлтийн дүн | |
| Тоног төхөөрөмжийн хөнгөлөлтийн дүн | |
| Бусад хөнгөлөлт | |
| Нөхөн төлбөрийн нийт дүн | |

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

**Тайлбар:** Хэрэглэгчид гэрээ байгуулах үед холболт, шилэн кабель, суурилуулалт болон тоног төхөөрөмжийн зардлаас хөнгөлөлт олгосон бөгөөд бодитоор үүссэн, баримтаар нотлогдох хөнгөлөлтийн төлөгдөөгүй хэсгийг “Нөхөн төлбөр” гэнэ. Хэрэглэгч гэрээний үндсэн хугацаа дуусахаас өмнө өөрийн санаачилгаар гэрээг цуцалсан тохиолдолд Нөхөн төлбөрийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлнө.

## ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

| ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Интернэтийн холболтын мониторинг** | **Техникийн тусламж** | **Шалгалт, оношилгоо эхлүүлэх хугацаа** | **Гэмтэл, саатлыг сэргээх зорилтот хугацаа** | **Төлөвлөгөөт тасалдлын мэдэгдэл** | **Төлбөрийн зохицуулалт** |
| 24/7 | 24/7 | 30 минутын дотор | Гэмтлийн шинж чанар, техникийн нөхцөлөөс хамаарна. Боломжтой бол 4 цагийн дотор сэргээхийг зорьж ажиллана. | Боломжит нөхцөлд 24-өөс доошгүй цагийн өмнө | Гэрээний 3.6 дахь заалтын дагуу |

**Нийлүүлэгчийг төлөөлж**
Нэр: _____
Албан тушаал: _____
Гарын үсэг: _____

**Хэрэглэгчийг төлөөлж**
Нэр: _____
Албан тушаал: _____
Гарын үсэг: _____

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*

*Энэхүү гэрээ нь байгууллагын нууцад хамаарах мэдээлэл тул өөр бусад этгээдэд хувилж тараах, нийтийн хүртээл болгохыг хориглоно.*